

ҮАГ

Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийгдсэн гүйцэтгэлийн аудит

2005 оны 1 дүгээр сар

Сонгуулийн зориулалттай ажил, үйлчилгээнд тендерийн холбогдолтой хууль тогтоомж хэрэгжихгүй байна.

Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2004 оны сонгуульд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт

Улаанбаатар хот

Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт	3
	Аудитын хамарсан хүрээ, арга зүй, аудитын стандартын талаархи мэдэгдэл	4
	Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
	Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	5

Аудитын дүн	Төсвийн хөрөнгийн зарцуулалтын арвилан хэмнэлт, үр ашиг	6
	Төсвийн хөрөнгийн зарцуулалтын зориулалт, тайлагнал	10

Дүгнэлт		12
----------------	--	----

Холбогдох байгууллагын санал	Сонгуулийн ерөнхий хорооны санал	14
	Үндэсний аудитын газрын тайлбар	19

Зөвлөмж		21
Хавсралт		22

Ерөнхий зүйл

Аудитын
зорилт

Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын (УИХ) болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын (ИТХ) 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийв.

УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараахь асуудлыг шалгаж дүгнэлт гаргахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Төсвөөс олгосон хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулсан эсэх;
- Батлагдсан төсвийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулж тайлагнасан эсэх;

Дээрх зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараахь чиглэлээр аудитын холбогдох горимыг хэрэгжүүлэв:

- 2004 оны сонгуулийн зардлыг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.1-д дурдсан зардлын зүйлийг харгалзаж төлөвлөсөн эсэх;
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу хуваарилж зарцуулсан эсэх;
- УИХ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлангаас сонгогчдын нэрсийн жагсаалтын маягт хэвлүүлэх, хүргэх, сонгуулийн саналын хуудас хэвлүүлэх, сонгогчдын үнэмлэх шилжүүлэг хэвлүүлэх, хүргэх, сонгуулийн хууль тогтоомж хэвлүүлэх, тараах зэрэг зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримтаар тулган баталгаажуулах;

Ерөнхий зүйл

- Сонгогчдын нэрсийн жагсаалтын маягт, сонгуулийн саналын хуудас, сонгогчдын үнэмлэх, сонгуулийн хууль, тогтоомж хэвлүүлэхэд гарсан өртөг зардалд дүн шинжилгээ, харьцуулалт хийх;
- Орон нутгаас ирүүлсэн сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлангаас аймаг, нийслэлийн аудитын газраар шалгуулаагүй тайланг холбогдох баримтаар нарийвчлан шалгах;
- Нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй, хураангуй бүртгэлийн хөтлөлт, анхан шатны баримт материалын бүрдүүлэлт холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
- Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг тогтоосон хугацаанд нэгтгэж, холбогдох байгууллагуудад тайлагнасан эсэх.

Аудитын хамарсан хүрээ, арга зүй, аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитыг УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн зардлын гүйцэтгэлтэй холбоотой баримт материалд үндэслэн хийв.

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журамд тусгагдсан гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашигласнаас гадна судалгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийн сонгосон аудитын горимыг гүйцэтгэлээ.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дараахь хууль тогтоомжийг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.1 дэх заалт.

Ерөнхий зүйл

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2 “Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэсэн байх”.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.6 “Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”.
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 13.2 “Улсын төсвийн байгууллага батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна”.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3 “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болон оруулахыг хориглоно”.

Аудитын
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа

Гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн ахлах аудитор Г.Цэдэнбалжир, аудитор Ц.Батбаяр, шинжээч Б.Болормаа, Ц.Цолмон нар 2005 оны 1 дүгээр сарын 4-нөөс 1 дүгээр сарын 21-ний хооронд хийж гүйцэтгэв.

Аудитын дүн

Төсвийн
хөрөнгийн
зарцуулалтын
арвилан
хэмнэлт, үр
ашиг

Сонгуулийн ерөнхий хорооноос УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулагдах төсвийг Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 5.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.1-д дурдсан зардлын зүйл болон аймаг, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс 2004 оны 1 дүгээр сард шинэчлэн гаргаж ирүүлсэн сонгуулийн насны хүн амын судалгааг үндэслэн тооцож, УИХ-д санал оруулжээ.

УИХ-ын 2004 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 10 дугаар тогтоолоор УИХ-ын 2004 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 696,6 сая төгрөг, 2004 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 16 дугаар тогтоолоор аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны ээлжит сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 545,7 сая төгрөг, бүгд 1242,3 сая төгрөгөөр тогтоожээ.

УИХ-ын 2004 оны 16 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 198 дугаар тогтоолоор аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны ээлжит сонгуулийг явуулахад зарцуулах дээрх зардлын 112,5 сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахаар шийдвэрлэжээ.

УИХ-ын 2004 оны сонгуулийг товлон зарласнаас хойш Сонгуулийн ерөнхий хороо улс даяар сонгуулийн бэлтгэл ажиллагааг ханган, сонгуулийг зохион байгуулах үүрэг бүхий сонгуулийн тойргийн 76 хороо, түүний салбар 338 хороо, хэсгийн 1645 хороог хуулийн хугацаанд байгуулж, төрийн байгууллага, улс төрийн намын болон нам бус төлөөлөгч, нийт 16,5 мянга орчим хүнийг гишүүнээр ажиллуулжээ.

УИХ-ын 2004 оны сонгуулийн санал авах ажиллагаа 6 дугаар сарын 27-ны өдөр 1650 байнгын болон түр санал авах байранд явагдаж, нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн 1330 610 сонгогчдоос 1058 683 сонгогч саналаа өгсөн нь нийт сонгогчийн 82,0 хувь болжээ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн санал хураах ажиллагаа 2004 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 1661 санал хураах байранд явагдаж, сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн 1089 252 хүнээс 732205 сонгогч саналаа өгсөн нь нийт сонгогчийн 67,2 хувь болжээ.

Аудитын дүн

УИХ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс 1000,0 сая төгрөг, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 112,5 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хорооны хуваарийн дагуу шилжүүлжээ.

Сонгуулийн ерөнхий хороо УИХ-ын сонгуульд 566,6 сая төгрөг, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд 454,1 сая төгрөг, бүгд 1020,7 сая төгрөг зарцуулж, төсвийг УИХ-ын сонгуульд 129,9 сая төгрөгөөр, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд 91,7 сая төгрөгөөр, бүгд 221,6 сая төгрөгөөр хэмнэжээ.

УИХ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлээс үзэхэд Баян-Өлгий, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс аймгийн тойргийн болон сонгуулийн хороод 6,8 сая төгрөг, Сонгуулийн ерөнхий хороо 84,7 сая төгрөг, бүгд 91,7 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, 2004 оны эцэст 91,5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ. Харин Сүхбаатар аймгийн тойрог, сонгуулийн хороо төсвөөс хэмнэгдсэн 208,0 мянган төгрөгийг улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

УИХ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг зардлын зүйл ангиар нь авч үзвэл:

- Хүмүүсийн ажлын хөлс, урамшууллын зардлыг 49,7 сая төгрөгөөр буюу 22,3 хувиар,
- Сонгуулийн саналын хуудас хэвлүүлэх зардлыг 32,5 сая төгрөг буюу 14,5 хувиар,
- Сонгогчийн үнэмлэх, шилжүүлэг хэвлүүлэх, хүргүүлэх зардлыг 27,4 сая төгрөг буюу 12,3 хувиар,
- Унааны зардлыг 23,8 сая төгрөг буюу 10,7 хувиар,
- Санал авах байр бэлтгэх, саналын хайрцаг хүргэх зардлыг 27,6 сая төгрөгөөр буюу 12,4 хувиар,
- Сургалт, семинар зохион байгуулах, сонгууль сурталчлах зардлыг 15,1 сая төгрөг буюу 6,8 хувиар тус тус хэмнэсэн нь нийт хэмнэлтийн 176,1 сая төгрөг буюу 78,9 хувийг эзэлж байна.

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн үйл ажиллагаанд хэрэглэх саналын хуудас, сонгогчийн үнэмлэхийг найдвартай хяналтын дор хийлгэх зорилгоор Засгийн

Аудитын дүн

газрын хэвлэх үйлдвэрт гэрээгээр хэвлүүлжээ.

Гэтэл тус хорооноос саналын хуудас хэвлүүлэх эх бэлтгэх ажиллагаанд алдаа гарснаас УИХ-ын сонгуулийн 64 дүгээр тойрогт бие даан нэр дэвшигч Ринчиннямын Амаржаргалын овгийг Ренчинням гэж бичсэнээс 21700 ширхэг саналын хуудсыг дахин хэвлүүлж 477,4 мянган төгрөгийн, мөн УИХ-ын сонгуулийн 51 дүгээр тойрогт “Эх орон-Ардчилал” эвслээс нэр дэвшигч Сандуйн Жаргалын овгийг Сундуйн Жаргал гэж буруу бичсэнээс 12200 ширхэг саналын хуудсыг дахин хэвлэж 268,4 мянган төгрөг, бүгд 746,1 мянган төгрөгийн үргүй зардал гаргажээ.

Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан саналын хуудас, сонгогчийн үнэмлэхийн тайлан тооцоонд аудит хийх гэсэн боловч тухайн үед ажил хариуцаж байсан тус хорооны ахлах референт Д.Баяндүүрэн АНУ-д 1 жилийн хугацаатай явсан учраас уг материалтай танилцаж чадаагүй болно.

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хуулийн 38.1-д заасны дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг тус хороо зохион байгуулалгүй ажиллаж иржээ.

Тухайлбал, сонгуулийн үйл ажиллагаанд зориулсан төрийн далбаа хийлгэх гүйцэтгэгчийг тендер зарлалгүй өөрсдөө сонгон гэрээ хийжээ. “Баянхайрханы урчууд” хоршоо сонгууль явуулах хэсгийн байран дээр мандуулах 1000 ш төрийн далбааг хийх гэрээ байгуулж гүйцэтгэн, төлбөрөө нэхэмжлэхдээ гэрээнд тусгагдаагүй НӨАТ-т 1800,0 мянган төгрөгийг нэмж нэхэмжилснийг тус хоршоогоор төлүүлж, улсын төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоолоо. (Энэ байгууллага нь НӨАТ төлөгч биш болохыг Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн дарга Ж.Магсаржав тодорхойлсон болно.)

Үүний зэрэгцээ “Экимто” ХХК-иар “УИХ-ын сонгууль зохион байгуулж явуулахад холбогдох заавар журам”-ын эмхэтгэл 12000 ширхэгийг 6000,0 мянган төгрөгөөр, “Соёмбо принтинг” ХХК-иар санал авах журам бүхий өнгөт зурагт хуудас 2400 ширхэгийг 4320,0 мянган төгрөгөөр, сонгуульд оролцохыг уриалсан зурагт хуудас 4000 ширхэгийг 6560,0 мянган төгрөгөөр, бүгд 10880,0 мянган төгрөгөөр хэвлүүлэх гэрээ хийхдээ тендерийн холбогдолтой хууль тогтоомжийг мөрдөөгүй байна.

Аудитын дүн

УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагаанд зориулж хэвлүүлсэн болон бэлтгэсэн заавар журам, хууль тогтоомжийн эмхэтгэл, сонгуульд оролцохыг уриалсан зурагт хуудас зэргийг гаргасан зардлаар зарлага болгон, хуваарийн дагуу тарааж үлдэгдлийг улс төрийн нам, нэр дэвшигчид, түүний сурталчилгааны багт гэх мэтээр хуваариас гадуур бүртгэлгүй тараасан байна. Тухайлбал:

- УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд дахин санал өгөхөөс хязгаарлах, хяналт тавих зорилгоор зүүн гарын долоовор хуруунд тэмдэг тавих бэхийг Энэтхэг улсаас 7200 ширхэгийг авчирч бүрэн зарлага болгосон. Гэтэл Сонгуулийн ерөнхий хороонд 2160 ш бэх үлдэгдэлтэй байна.
- Монгол Улсын Үндсэн хууль 2000 ширхэгийг 1800,0 мянган төгрөгөөр хэвлүүлэн 1780 ширхэг тарааж, үлдэгдэл 220 ширхэг нь бүртгэлгүй хуваарилагдсан.
- УИХ-ын сонгуулийн хууль, холбогдох заавар журмын эмхэтгэл тус бүр 12000 ширхэгийг 10800,0 мянган төгрөгөөр хэвлүүлснээс тус бүр 11850 ширхэг хуваариар тараагдаж, үлдэх 150 ширхэг бүртгэлгүй тараагдсан.
- Сонгуулийг сурталчлах уриа бүхий зурагт хуудас 9100 ширхэгийг 15686,0 мянган төгрөгөөр хэвлүүлж, 8960 ширхэг нь тараагдаж, үлдэгдэл 140 ширхэг буюу 249,2 мянган төгрөгийн үлдэгдэл СЕХ-гоор тараагдсан баримтгүй байна.

Сонгуулийн ерөнхий хороо өөрийн аппаратын үйл ажиллагааны хөрөнгө оруулалт болон урсгал зардлаар тооцогдох ёстой компьютер, дижитал камер болон аж ахуйн зориулалттай материал, бичиг хэргийн зүйл худалдаж авах, шуудан холбоо, тээвэр, гадаад томилолтын зардал зэрэг бүгд 8,6 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагааны зардлаас зарцуулж, урсгал зардлыг энэ хэмжээгээр хэмнэжээ. (Сонгуулийн ерөнхий хорооны урсгал зардлын төсвийн үлдэгдэл 9,3 сая төгрөгийг 2004 оны 12 дугаар сарын 31-нд Сангийн сайдын тушаалаар улсын төсөвт төвлөрүүлжээ.)

Аудитын дүн

Төсвийн
хөрөнгийн
зарцуулалтын
зориулалт,
тайлагнал

Сонгуулийн ерөнхий хороо УИХ-ын сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг 2004 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр 130 дугаар, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг 2004 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр 170 дугаар албан бичгээр Санхүү, эдийн засгийн яаманд гаргаж тайлагнажээ.

Сонгуулийн ерөнхий хорооноос УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд зориулж улсын төсвөөс сонгуулийн тойрог, салбар, хэсгийн хороодод олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг зарим аймаг тогтоосон хугацаанд нь гаргаж ирүүлээгүй, гарын үсэг, тамга тэмдэггүй тайлан ирүүлсэн, аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар баталгаажуулаагүй зэрэг зөрчил гарсан байна.

- Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Д.Бүүвэй улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг факсаар ирүүлсэн бөгөөд тайлан нь гарын үсэггүй, тамга тэмдэг дараагүй (Сонгуулийн ерөнхий хорооноос зардлын ангиллаар хүргүүлсэн төсвийг нэг ч төгрөгийн зөрүүгүй гүйцэтгэлээр гаргасан), аймгийн аудитын газраар баталгаажуулаагүй албан ёсны бус байлаа.

Аудитын явцад Баянхонгор аймгийн аудитын газраар шалгуулахад тус аймгийн сонгуулийн тойрог, салбар хороодод улсын төсвөөс олгосон 21,7 сая төгрөгийн зарцуулалтаас сонгуулийн 9 дүгээр тойргийн Бууцагаан сумын салбар хороо 139,8 мянган төгрөгийн, Заг сумын салбар хороо 132,3 мянган төгрөгийн, 9 дүгээр тойргийн хороо 418,8 мянган төгрөгийн, бүгд 690,9 мянган төгрөгийн зарцуулалтын баримт дутуу байв. Үүний зэрэгцээ Галуут сумын салбар хороо сонгуулийн үйл ажиллагаанд төсвөөс зарцуулсан тайлангаа ирүүлээгүйгээс гүйцэтгэлд нь аудит хийх боломжгүй байжээ.

- Өвөрхангай аймгийн сонгуулийн 4 тойргийн хороо УИХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд зориулж улсын төсвөөс олгосон 20,6 сая төгрөгийн зарцуулалтад аймгийн аудитын газраар аудит хийлгээгүй тайланг мөн факсаар ирүүлсэн байна.

Аудитын дүн

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланд Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Өмнөговь, Төв, Увс, Ховд, Хэнтий, Улаанбаатар зэрэг аймаг, нийслэлийн орон нутгийн сонгуулийн 14 хороо аудит хийлгээгүй байна.

Сонгуулийн ерөнхий хороо нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтөлж байгаа боловч, анхан шатны баримт бүрдүүлэхдээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн зохих заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- Харилцах болон мөнгөн кассаас зарлага болгож буй зарим баримтууд (нэхэмжлэхтэй хавсаргасан зарлагын паданд уг барааг хүлээн авсан хүний гарын үсэггүй) бүрдэл дутуу, худалдаж авсан материалаа орлогод аваагүй, зарлагыг шилжүүлсэн мөнгөний дүнгээр тооцож, материалын үлдэгдлийг данс бүртгэлд тусгаагүй,
- Дараа тайлан гаргахаар бэлэн мөнгө авсан зарим хүмүүстэй тооцоо хийхдээ үлдэгдэл мөнгийг нь орлого болгох, хэтрэлтийг олгох буюу төлүүлэх, авлага, өглөгийн дансанд тусгаагүй шууд гүйцэтгэлээр зарлага болгох,
- Сонгуулийн үйл ажиллагааны тээврийн зардлын замын тооцооны зарим баримт нь хэрэглэгчийн гарын үсэггүй байхад мөнгийг зарлага болгон олгох,
- Аж ахуйн материал, принтерийн хор, компьютерийн сэлбэг, хатуу диск, маус зэргийг хэн авсан нь тодорхойгүй баримтаар зарлага болгох, материал авсан хүн тайлан гаргаагүй гэх мэт нийтлэг зөрчлүүд илэрлээ.

Сонгуулийн ерөнхий хороо өөрийн аппаратын болон сонгуулийн үйл ажиллагаанд ихээхэн хөрөнгө зарцуулж, тайлагнаж байгаа боловч нярав, эд хариуцагч байхгүй, нягтлан бодогчоор нь УИХ-ын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч хавсран ажиллаж байна.

Дүгнэлт

УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын явцад олж авсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа тооцоонд тулгуурлан дор дурдсан дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ❖ Сонгуулийн ерөнхий хороо УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд 1020,7 сая төгрөг зарцуулж, (аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуулийн зардалд УИХ-ын сонгуулийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 129.9 сая төгрөгийг суутган тооцож санхүүжүүлсэн) 91,5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.
- ❖ Монгол Улсын үндсэн хууль, сонгуулийн хууль, түүнийг хэрэгжүүлэх аргачлал, заавар, журам, сонгуулийг сурталчлах зурагт уриа хуудсыг хэвлүүлэх, төрийн далбаа хийлгэхдээ гүйцэтгэгчийг хуулийн дагуу сонгон шалгаруулалгүй өөрсдөө сонгон гэрээ хийжээ.
- ❖ Сонгуулийн зардал хэдийгээр нийт дүнгээрээ хэмнэгдсэн ч СЕХ-ны аппаратын хөрөнгө оруулалт, урсгал зардлаар тооцогдох ёстой компьютер, дижитал камер, аж ахуйн зориулалтай материал, бичиг хэргийн зүйл худалдаж авах, шуудан холбоо, тээвэр, гадаад томилолтын зардал зэрэг бүгд 8,6 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагааны зардлаас гаргасан нь тус байгууллагын 2004 оны урсгал зардлыг хэмнэсэн мэт харагдахад нөлөөлжээ.
- ❖ Зарим аймаг УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын тайланг хугацаанд нь гаргаж ирүүлээгүй, гарын үсэг, тамга тэмдэг, аудитын байгууллагын дүгнэлтээр баталгаажуулаагүй байна.
- ❖ Сонгуулийн ерөнхий хорооны анхан шатны зарим баримтын бүрдүүлэлт Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу бүрэн хийгдэж чадахгүй байна.

Дүгнэлт

УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн үйл ажиллагаанд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын явцад төрийн далбаа хийсэн “Баянхайрханы урчууд” хоршоогоор 1800,0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Холбогдох байгууллагын санал

Сонгуулийн
ерөнхий
хороо



**МОНГОЛ УЛС
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО**

Улаанбаатар-38
Ж Самбуугийн гудамж-11, Засгийн газрын XI байр
Утас: 26-09-75. Факс: 32-69-75.
E-mail: gacm@mongol.net
http://www.gac.gov.mn

2005.02.01 № 06

танай _____-ны № _____-т

Гүйцэтгэлийн аудитын тайланд
тайлбар гаргаж хүргүүлэх тухай

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлттэй танилцлаа.

Тайланд дурдсан зарим асуудлаар тайлбар гаргаж, үүгээр хүргүүлэв.



ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

050444

Холбогдох байгууллагын санал

2004 ОНЫ СОНГУУЛИЙН УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТЭД СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ӨГӨХ ТАЙЛБАР

Тайлбар 1-ийг үзнэ үү.

1. Гүйцэтгэлийн аудитын тайлан /цаашид "тайлан" гэж товчлов/-гийн 8 дугаар нүүрт: "...746,1 мянган төгрөгийн үргүй зардал гаргажээ" гэсний тухайд:

1.1. Хоёр нэр дэвшигчийн эцгийн нэрийн тус бүр нэг үсгийг ташаарч хэвлэсэн хэрэг бөгөөд энэ нь нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичигтэй ч холбоотой юм. Басхүү сонгуулийн хуульд нэр дэвшигчийн нэрийг хэдийд ч татаж болохоор заасан байдаг ч гэлээ манай хороо нэмэлт зардал төсвөөс гаргахгүй байх үүднээс нийт нэр дэвшигчдэд болон нам, эвсэлд саналын хуудас хэвлэгдсэнээс хойш нэр татахгүй байхыг анхааруулж, хэрэв ийм явдал гаргавал тухайн этгээдээр зардлыг гаргуулах болохыг мэдэгдэж зохих арга хэмжээг авснаар урьд өмнөх сонгуулиудаар саналын хуудас дахин хэвлэж төсвөөс нэмж зардал гаргадаг байсныг бүрэн болиулж ихээхэн хөрөнгийг хэмнэж чадсан болно.

Хороо саналын хуудас хэвлүүлэх зардлыг гүйцэтгэлээр шилжүүлсэн. Дахин дахин шилжүүлээгүй, саналын хуудас хэвлэхээр төлөвлөсөн 48 083.8 сая төгрөгийн зардлаас 33 384.8 сая төгрөг зарцуулж нийт 14 699.0 сая төгрөг хэмнэсэн болно.

Ер нь Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн ажлын гүйцэтгэлийг зохих хяналтын дагуу хэвийн, цаг хугацаанд нь үе шаттайгаар хангаж ирсэн.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

2. Тайлангийн 8 дугаар нүүрт Аудитын хамрах чиглэл, ашиглах шалгуурт анхнаасаа байгаагүй асуудалд дүгнэлт хийж "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийн 38.1-д заасны дагуу тендер зарлаж, ажлын гүйцэтгэчийг сонгон гэрээ байгуулах талаар тус Хороо мөрдөхгүй ажиллаж иржээ" гэсний тухайд:

2.1. Сонгуулийн саналын хуудас, үнэмлэх бусад баримт бичгийг тендерээр хэвлүүлэх нь хугацааны хувьд, нууцлалын хувьд боломжгүй зүйл юм. Санхүү, эдийн засгийн сайдын Бүх шатны төсвийн захирагч нарт өгсөн 2001 оны 016/2350 дугаар албан даалгаварын Хоёрт "сонгуулийн зардал"-ыг тендерийн хууль тогтоомжид хамаарахгүй болохыг зориуд зааж өгсөн болно.

2.2. Хэрэв Тендерийн хуулийг дагаж мөрдвөл сонгуулийн бэлтгэл ажлыг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх боломжгүй болно. УИХ-ын сонгуулийн кампанит ажлын хугацаа 75 хоног байдаг бол Орон нутгийнх 21 хоног байдаг. Дээрх 2 сонгуулийг сонгууль зарлахаас 3-4 хоногийн өмнө тулгаж зарласан. Үүн дотор УИХ-ын сонгуулийн тухайд Сонгуулийн ерөнхий хороо сонгууль зарласнаас хойш 10 хоногийн дотор саналын хуудас хэвлүүлэхээс бусад бүх бэлтгэх материалыг бэлэн болгож хүргүүлдэг. Учир нь, тэдгээр хууль тогтоомж нь санал хураах өдрөөс өмнө сонгуулийн хэвийн явцыг хангахад чиглэгдсэн байх ба аймгийн төв рүү хүргэгдэж цаашлаад сонгуулийн тойргийн бүх хороодод болон цаашилбал 338 гаруй салбар хороонд, 1650 хэсгийн хороонд тараагдаж, 16500 гаруй сонгуулийн ажилтнуудын албан хэрэгцээнд буюу тэдний ажиллах байрт зориулагдахаас гадна нэр дэвшигчид, тэдгээрийн намд болон сонгогчдод хүргэгддэг.

Холбогдох байгууллагын санал

2

Ингээд үзэхээр 75 буюу эсхүл 21 хоногийн хэд хоногт нь тендер зарлаж явуулаад, хэд хоногт нь хийлгээд хэд хоногт нь хүргүүлээд, хэд хоногт нь тараалгах вэ гэдэг нь тун ойлгомжгүй байна. Нээлттэй тендерээр ажил гүйцэтгүүлэх тохиолдолд гэхэд л хамгийн хурдандаа 40-өөс доошгүй хоног, хязгаарлагдмал тендерийнхэд 21-ээс доошгүй хоног шаардана.

Тайлбар 3-ыг үзнэ үү.

2.3. Мөн тендерийн хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй гэж үзэж буй бол саналын хуудас, сонгогчийн үнэмлэх зэргийг төрийн тусгай хамгаалалттайгаар Засгийн газрын хэвлэх үйлдвэрээр дээд зэргийн төвшинд хяналттайгаар хэвлүүлсэн нь ч зөрчил болох нь. Өмнө нь ингэж хэвлэгддэггүй байсныг бид ийн өөрчилсөн хэрэг.

3. Тайлангийн 8 дугаар нүүрт: "Тухайлбал, "Баянхайрханы урчууд" хоршоо сонгууль явуулах хэсгийн байран дээр мандуулах 1000 ш төрийн далбааг хийх гэрээ байгуулж гүйцэтгэн, төлбөрөө нэхэмжлэхдээ гэрээнд тусгагдаагүй НӨАТ-т 1800,0 мянган төгрөгийг нэмж нэхэмжилснийг төлүүлж, улсын төсвийн орлого болгохоор төлбөрийн акт тогтоолоо. (Энэ байгууллага нь НӨАТ төлөгч биш болохыг Дархан-Уул аймгийн Татварын хэлтсийн дарга Ж.Магсаржав тодорхойлсон болно)" гэсний тухайд:

3.1. Тухайн гэрээнд төлбөр, НӨАТ-ийг саадгүй төлнө гэж заасан ба нэг бүрийг 12000 төгрөгөөр үнэлсэн болно. Чухамдаа энэ үнийн дүн дээр НӨАТ тооцсон нэхэмжлэхийн дагуу 13800,0 мянган төгрөг шилжүүлсэн байна. Гэрээнд тусгагдаагүй биш тусгагдсан бөгөөд тусгагдаагүй байсан ч НӨАТ-ийн тухай хуулийн дагуу шилжүүлэх учиртай.

3.2. НӨАТ төлөгч биш тухай тодорхойлолт нь үндэслэлгүй гэж үзэж байна. Жилд 10000,0 мянган төгрөгөөс илүү орлоготой иргэн, аж ахуйн нэгж НӨАТ төлөгчид бүртгүүлэх журамтай. Сонгуулийн ерөнхий хороо 13800,0 мянган төгрөг шилжүүлснээр тухайн Хоршоо НӨАТ төлөгч шууд болчихож байгаа юм. Харин НӨАТ-ыг улсын төсөвт оруулаагүй нь тухайн байгууллагад хамааралтай асуудал.

Тайлбар 4-ийг үзнэ үү.

4. Тайлангийн 9 дүгээр нүүрт: "УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн үйл ажиллагаанд зориулж хэвлүүлсэн болон бэлтгэсэн заавар журам, хууль тогтоомжийн эмхэтгэл, сонгуульд оролцохыг уриалсан зурагт хуудас зэргийг гаргасан зардлаар зарлага болгон, хуваарийн дагуу тарааж үлдэгдлийг улс төрийн нам, нэр дэвшигчид, түүний сурталчилгааны багт гэх мэтээр хуваариас гадуур бүртгэлгүйгээр тараасан байна. Тухайлбал:

- УИХ-ын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд дахин санал өгөхөөс хязгаарлах, хяналт тавих зорилгоор зүүн гарын долоовор хуруунд тэмдэг тавих бэхийг Энэтхэг улсаас 7200 ширхэгийг авчирч бүрэн зарлага болгосон. Гэтэл Сонгуулийн ерөнхий хороонд 2160 ш бэх үлдэгдэлтэй байна.
- Монгол улсын Үндсэн хууль 2000 ширхэгийг 1800,0 мянган төгрөгөөр хэвлүүлэн 1780 ш тарааж, үлдэгдэл 220 ш нь бүртгэлгүй хуваарилагдсан.
- УИХ-ын сонгуулийн хууль, холбогдох заавар журмын эмхэтгэл тус бүр 12000 ширхэгийг 10800,0 мянган төгрөгөөр хэвлүүлснээс тус бүр 11850 ш тараагдаж, үлдэх 150 ш бүртгэлгүй тараагдсан байна.
- Сонгуулийг сурталчлах уриа бүхий зурагт хуудас 9100 ширхэгийг 15686,0 мянган төгрөгөөр хэвлүүлж, 8960 ш нь тараагдаж үлдэгдэл 140 ш буюу 249,2 мянган төгрөгийн үлдэгдэл СЕХ-гоор тараагдсан баримтгүй байна" гэсний тухайд:

Холбогдох байгууллагын санал

3

4.1. Тусгай зориулалтын бэхийг УИХ-ын болон Орон нутгийн 2004 оны ээлжит сонгууль, Ерөнхийлөгчийн 2005 оны ээлжит сонгууль зэрэгт хэрэглэхээр тооцож Энэтхэг улсаас нийт 9 хайрцаг буюу 7200 ширхэгийг авчирсан бөгөөд эдгээрийг бүгдийг бүрэн зарлага болгоогүй юм. Харин эдгээр бэх авчирхаас өмнө Сонгуулийн ерөнхий хороонд 1500 ширхэг бэх хадгалагдаж байсан. Үүнтэй нийлээд нийт 8700 ширхэг бэхнээс УИХ-ын болон Орон нутгийн сонгуульд тус бүр 3235 ширхэг буюу нийт 6470 ширхэг бэх хуваарилсан бөгөөд Ерөнхийлөгчийн сонгуульд хэрэглэх нийт 2160 ширхэг бэх Хороонд хадгалагдаж байгаа болно.

4.2. Сонгуулийн ерөнхий хорооноос хэвлүүлсэн хууль тогтоомж, зурагт хуудасны нийт ширхэгээс тодорхой тоогоор тус Хороонд авч үлдсэн бөгөөд энэ нь Сонгуулийн ерөнхий хороонд цаашид үлгэр загвар, сургалтад хэрэглэхээр хадгалах/тухайлбал, хоёр сонгуульд зориулсан зурагт хуудсаас 3 төрөл тус бүрээс 10 ширхэгийг авсан буюу нийт 30 ширхэг одоо Хороонд хадгалагдаж байна/ болон Сонгуулийн ерөнхий хорооны гишүүд, ажлын хэсгийнхэн, сонгуульд оролцогч нам, эвсэл, түүний нэр дэвшигчид, хэвлэл мэдээллийнхэн болон хүн ихээр төвлөрсөн газар байрлуулахаар тооцож авсан материал юм. Жишээ нь, МАХН, Эх орон-Ардчилал эвслийн удирдлага зэрэгт тус бүр 40 ширхэг сонгуулийн хууль тогтоомж гардуулж өгсөн ба тэднээс тодруулах боломжтой. Сонгуулийн ерөнхий хорооны нийт 11 гишүүн, ажлын хэсгийн 8 гишүүн, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчдэд гээд албан хэрэгцээнд өгөгдсөн ба мөн тэдгээрээс тодруулж шалгаж болох юм.

Тайлбар
5-ыг үзнэ үү.

5. Тайлангийн 9, 12 дугаар нүүрт: "Сонгуулийн ерөнхий хороо өөрийн аппаратын үйл ажиллагааны хөрөнгө оруулалт болон урсгал зардлаар тооцогдох ёстой компьютер, дижитал камер болон аж ахуйн зориулалттай материал, бичиг хэргийн зүйл худалдаж авах, шуудан холбоо, тээвэр, гадаад томилолтын зардал зэрэг бүгд 8,6 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагааны зардлаас зарцуулж, урсгал зардлыг энэ хэмжээгээр хэмнэжээ. (Сонгуулийн ерөнхий хорооны урсгал зардлын төсвийн үлдэгдэл 9,3 сая төгрөгийг 2004 оны 12 дугаар сарын 31-нд Сангийн сайдын тушаалаар улсын төсөвт төвлөрүүлжээ.)", "...Сонгуулийн зардал хэдийгээр нийт дүнгээрээ хэмнэгдсэн ч СЕХ-ны аппаратын хөрөнгө оруулалт, урсгал зардлаар тооцогдох ёстой компьютер, дижитал камер, аж ахуйн зориулалттай материал, бичиг хэргийн зүйл худалдаж авах, шуудан холбоо, тээвэр, гадаад томилолтын зардал зэрэг бүгд 8,6 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагааны зардлаас гаргасан нь тус байгууллагын 2004 оны урсгал зардлыг хэмнэсэн мэт харагдахад нөлөөлжээ" гэсний тухайд:

5.1. Компьютер, дижитал камерийг сонгуулийн ажлын зайлшгүй шаардлагаар сонгуулийн зардлаас худалдан авсан бөгөөд манай Хорооны төсөвт хөрөнгө оруулалтын шинжтэй нэг ч зардал тусгагдаж батлагддаггүй учир өөр санхүүжилтийн эх үүсвэр байхгүй юм. Мөн бичиг хэргийн болон шуудан холбоо, тээврийн зардлыг сонгуулийн үед батлагдсан сонгуулийн төсвөөс гаргасан нь ямар нэгэн хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл биш бөгөөд Хорооны урсгал төсөв нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хэмжээнд тодорхойлогдсон байдаг бол сонгуулийн төсөв нь сонгуулийн жил байгууллагын үндсэн чиг үүрэг болох сонгуулийг улс даяар зохион явуулахад 100 хувь зарцуулагддаг онцлог бий. Сонгуулийн үед дээрх зардлыг хоёр төсвөөс ялгаж шилжүүлэхэд хэцүү бөгөөд төсөв тэр хэмжээгээр хэмнэгдсэн.

Тайлбар
6-г үзнэ үү.

6. Тайлангийн 11 дүгээр нүүрт: "Сонгуулийн ерөнхий хороо өөрийн аппаратын болон сонгуулийн үйл ажиллагаанд ихээхэн хөрөнгө зарцуулж, тайлагнаж байгаа

Холбогдох байгууллагын санал

4

боловч нярав, эд хариуцагч байхгүй, нягтлан бодогчоор нь УИХ-ын ТГ-ын ерөнхий нягтлан бодогч хавсран ажиллаж байна" гэсний тухайд:

6.1. Энд Сонгуулийн ерөнхий хорооноос шалтгаалж байгаа зүйл огт байхгүй. Харин Сонгуулийн ерөнхий хороо одоогийн орон тооны 4 ажилтантай байх асуудлаа шаргуу тавьсны хүчинд шийдүүлж УИХ-ын төсвөөс тусдаа бие даасан төсөв батлуулж авсан боловч дахин хоёр ажилтан авах албан санал хүсэлтээ зохих журмын дагуу 2003, 2004, 2005 оны төсвийн төсөл, бизнес төлөвлөгөөндөө удаа дараа тусгаж тавиад шийдэгдээгүй. Мөн энэ талаар сонгуулийн ажлын тайланд тусгаж УИХ-д хүргүүлсэн болно.

7. Дээрх төсвөөс Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс онцгой анхаарч ажилласны үр дүнд нийт дүнгээрээ ихээхэн хэмнэлт гарсан билээ.

Үүнээс гадна тайланд нэр дурдсан аймгуудын тойргийн хороод тодорхой хэмнэлт гаргаж ажилласан ба улсын хэмжээнд сонгуулийн хороод хуваарилсан төсвийг нийт дүнгээс хэтрүүлж зарцуулаагүй болно.

8. Мөн Сонгуулийн ерөнхий хороо өөрөөс хамаарах бүхнийг хийж сонгуулийн санал хураалтын 3 төрлийн бүх хайрцагийг төсвөөс зардал гаргахгүй олон улсын стандартын хайрцагаар сольсон, лацны зардлыг үнэгүй шийдвэрлэсэн болно. Эдгээр нь хэдэн зуун мянган доллараар тооцогдож байгааг тайланд тусгаж өгөхийг хүсье.

Тайлбар
7-г үзнэ үү.

Тайлбар
8-ыг үзнэ үү.

Холбогдох байгууллагын санал

Үндэсний аудитын газрын тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.2-т “Аудит хийлгэсэн байгууллагаас ирүүлсэн саналыг судлан үндэслэлтэй гэж үзвэл тайланд засвар оруулах, үндэслэлгүй гэж үзвэл өөрийн дүгнэлтийг нэмэлт нотлох зүйлээр бататгах арга хэмжээ авах” гэж заасны дагуу дараахь тайлбарыг өгч байна.

Тайлбар 1. Сонгуулийн ерөнхий хорооноос саналын хуудас хэвлүүлэх эх бэлтгэх ажиллагаандаа хариуцлагагүй хандсанаас алдаа гаргаж УИХ-ын сонгуулийн 64 дүгээр тойрогт бие даан нэр дэвшигч Ринчиннямын Амаржаргалын овгийг Ренчинням гэж бичсэнээс 21700 ширхэг саналын хуудсыг дахин хэвлүүлж 477,4 мянган төгрөгийн, мөн УИХ-ын сонгуулийн 51 дүгээр тойрогт “Эх орон-Ардчилал” эвслээс нэр дэвшигч Сандуйн Жаргалын овгийг Сундуйн Жаргал гэж буруу бичсэнээс 12200 ширхэг саналын хуудсыг дахин хэвлэж 268,4 мянган төгрөг, бүгд 746,1 мянган төгрөгийн үргүй зардал гаргасан нь тус хороо, Засгийн газрын хэвлэх үйлдвэрийн санхүүгийн баримтаар нотлогдож байгаа юм.

Тайлбар 2. Сонгуулийн ерөнхий хороо нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай” хуулиас Санхүү, эдийн засгийн сайдын бүх шатны төсвийн захирагч нарт өгсөн 2001 оны 016/2350 дугаар албан даалгаварыг дээгүүр үзэх нь хууль зөрчиж байгаа асуудал юм.

Тайлбар 3. Сонгуулийн ерөнхий хороо “Баянхайрханы урчууд” хоршоотой байгуулсан ажил үүрэг гүйцэтгэх гэрээний 8-т “төрийн далбаа бүрийг 12,000 төгрөгөөр 1000 ширхэгийг...” гэсэн заалтад НӨАТ-ын талаар юу ч тусгагдаагүй. Тус хоршоо Дархан-Уул аймгийн Татварын хэлтэст НӨАТ төлөгчөөр бүртгэгдээгүй учраас илүү авсан 1800,0 мянган төгрөгийг улсын төсөвт төлнө гэсэн ойлголт байхгүй. Тухайн хоршоо ч Дархан-Уул аймгийн Татварын хэлтэстэй НӨАТ-ын тооцоо хийгээгүй учраас илүү нэхэмжлэн авсан уг мөнгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон юм.

Тайлбар 4. УИХ-ын болон орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үйл ажиллагаанд зориулж хэвлүүлсэн болон бэлтгэсэн заавар журам, хууль тогтоомжийн эмхэтгэл, сонгуульд оролцохыг уриалсан зурагт хуудас, тэмдэг тавих бэх зэргийг гаргасан зардлаар зарлага болгосон. Гэтэл дээрх зүйлсийг хуваарь гаргаж тарааж, үлдсэн үлдэгдлийг баримтгүйгээр тараасан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтуудыг зөрчиж байгаа юм.

Тайлбар 5. Сонгуулийн ерөнхий хороо өөрийн аппаратын үйл ажиллагааны хөрөнгө оруулалт болон урсгал зардлаар тооцогдох

Холбогдох байгууллагын санал

ёстой компьютер, дижитал камер болон аж ахуйн зориулалттай материал, бичиг хэргийн зүйл худалдаж авах, шуудан холбоо, тээвэр, гадаад томилолтын зардал зэрэг бүгд 8,6 сая төгрөгийг сонгуулийн үйл ажиллагааны зардлаас зарцуулж, урсгал зардлыг энэ хэмжээгээр хэмнэсэн нь Монгол Улсын Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 13.2-т "...батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна" гэсэн заалтыг зөрчиж уг хөрөнгийг зориулалт бусаар ашигласан юм.

Тайлбар 6. Сонгуулийн ерөнхий хороо өөрийн аппаратын болон сонгуулийн үйл ажиллагаанд бүгд 1,2 тэрбум төгрөг зарцуулж, тайлагнаж байгаа боловч хөрөнгө хариуцан орлого, зарлагыг нь тооцож, тайлан гаргах нярав, эд хариуцагч байхгүй, нягтлан бодогчоор нь УИХ-ын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч Д.Жанчивдорж хавсран ажиллахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалтын дагуу анхан шатны болон нягтлан бодох бүртгэл бүрэн хөтлөгдөхгүй байгаа учраас энэ асуудлыг хөндөж тавьсан юм.

Тайлбар 7. Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс онцгой анхаарч ажилласны үр дүнд төсөвт зардлыг хэмнэж ажилласан гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Тайлбар 8. Сонгуулийн ерөнхий хороо БНСУ-ын Сонгуулийн үндэсний комиссын тусламжаар сонгуулийн санал авах хайрцаг, АНУ-ын Бүгд найрамдахчуудын хүрээлэнгээс саналын хайрцагны лац зэргийг хандиваар авч төсвийн хөрөнгийг хэмнэхэд нөлөө үзүүлжээ.

УИХ болон орон нутгийн ИТХ-ын 2004 оны сонгуулийн улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн дээрх 8-н зүйлтэй тайлбарыг авч үзээд 7,8 дахь тайлбараас бусад тайлбарыг хүлээн авах боломжгүй, тайланд засвар оруулах шаардлагагүй гэж үзлээ. Учир нь тайлан дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад материал ажлын баримтад хавсаргагдсан болно.

**Улсын Их Хурал болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2004 оны
сонгуулийн зардлын тооцоо**

мянган төг

№	Үзүүлэлт	Төсөв			Санхүүжилт		Гүйцэтгэлээр			Үлдэгдэл	СЕХ-нд төвлөрсөн
		УИХ	Орон нутгийн	Дүн	Сангийн яамнаас	ЗГНөөц хөрөнгөөс	УИХ	Орон нутгийн	ДҮН		
1	Архангай	20,805.8	24,484.4	45,290.2	44,484.4		20,000.0	24484.4	44484.4	-	
2	Баян-Өлгий	19,454.6	21,502.6	40,957.2	40,952.4		19,449.8	21499.8	40949.6	2.8	2.8
3	Баянхонгор	21,695.8	24,527.0	46,222.8	46,222.8		21,695.8	24527.0	46222.8	-	
4	Булган	15,136.7	17,299.9	32,436.6	32,436.6		15,136.7	17299.9	32436.6	-	
5	Говь-Алтай	19,205.2	21,629.1	40,834.3	40,693.4		19,064.3	21629.1	40693.4	-	
6	Говьсүмбэр	6,137.1	3,215.2	9,352.3	12,080.9	500.0	8,865.7	3415.2	12280.9	300.0	300.0
7	Дорноговь	16,710.8	14,016.1	30,726.9	19,882.1		5,866.0	14004.9	19870.9	11.2	11.2
8	Дорнод	14,046.7	16,572.0	30,618.7	33,144.4		16,572.4	16572.0	33144.4	-	
9	Дундговь	23,801.5	14,907.0	38,708.5	28,953.7		14,046.7	14907.0	28953.7	-	
10	Завхан	20,648.8	26,591.4	47,240.2	50,248.6		23,657.2	26591.4	50248.6	-	
11	Өвөрхангай	15,429.2	22,420.4	37,849.6	43,069.2		20,648.8	18271.0	38919.8	4,149.4	4,149.4
12	Өмнөговь	13,982.7	17,186.7	31,169.4	32,615.9		15,429.2	17186.7	32615.9	-	
13	Сүхбаатар	15,259.7	15,698.4	30,958.1	29,671.5		13,973.1	14787.0	28760.1	911.4	703.4
14	Сэлэнгэ	22,126.5	16,124.6	38,251.1	30,820.4		14,695.8	15717.1	30412.9	407.5	407.5
15	Төв	21,677.5	24,550.6	46,228.1	46,083.2		21,532.6	23550.6	45083.2	1,000.0	1,000.0
16	Увс	20,662.6	22,030.1	42,692.7	43,197.6		21,037.8	21896.6	42934.4	263.2	263.2
17	Ховд	23,979.7	21,403.2	45,382.9	42,065.8		20,662.6	21403.2	42065.8	-	
18	Хөвсгөл	18,701.0	29,312.8	48,013.8	53,292.5		23,979.7	29312.8	53292.5	-	
19	Хэнтий	10,638.9	20,476.2	31,115.1	39,172.8		18,696.6	20476.2	39172.8	-	
20	Дархан-Уул	6,730.9	9,459.0	16,189.9	20,097.9		10,638.9	9459.0	20097.9	-	
21	Орхон	8,865.7	7,312.7	16,178.4	14,043.6		6,730.9	7312.7	14043.6	-	
22	Улаанбаатар	35,042.4	42,680.2	77,722.6	40,770.3	35,897.6	33,987.7	42680.2	76667.9	-	
23	СЕХороо	305,838.9	112,355.4	418,194.3	216,000.0	76,079.4	180,224.3	27,158.6	207382.9	84,696.5	
	ДҮН	696,578.7	545,755.0	1,242,333.7	1,000,000.0	112,477.0	566,592.6	454,142.4	1,020,735.0	91,742.0	6,837.5

Үндэсний аудитын газар